



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/14

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1, аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02 ны өдрийн 08 дугаар тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02 хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоц халдварт бог малын мялзан өвчин бүртгэгдсэн Рашаант, Их-уул, Тосонцэнгэл, Төмөрбулаг сумдад хэрэгжиж байгаа хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт шалгалтын удирдамжийг хоёрдугаар, шаардлагатай зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтийг аймгийн шуурхай штабт 2023 оны 01 дүгээр сарын 23 ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд шаардлагатай 2,165,000 (хоёр сая нэг зуун жаран таван мянган) төгрөгийн шатахуун, томилолтын зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Завиуулав.2023

6717011071



Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 13-ны өдрийн  
А/14 дугаар захирамжийн 1 дүгээр  
хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГОЦ ХАЛДВАРТ БОГ МАЛЫН  
МЯЛЗАН ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ, ШАЛГАХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Л. Бямбасүрэн-(Онцгой байдлын газрын гамшгаас  
хамгаалах улсын ахлах байцаагч)

Гишүүдэд:

Б.Батдорж - (Мал эмнэлгийн газрын улсын ахлах байцаагч)

Б.Бямбасүрэн-(Хүнс хөдөө аж ахуйн газар мал үржлийн  
албаны дарга)

Б.Жамбалдорж-(Цагдаагийн хошууч)

Ажлын хэсгийн нарийн бичиг дарга:

Б.Мягмарсүрэн – (Мал эмнэлгийн газрын улсын ахлах байцаагч )

\_\_\_оОо\_\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 13-ны өдрийн  
А/14 дугаар захирамжийн 2 дугаар  
хавсралт

**“БОГ МАЛЫН МЯЛЗАН” ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ,  
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЭРЧИМЖҮҮЛЭХ, ЗӨВЛӨН  
ТУСЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Мал, амьтны гоц халдварт Бог малын мялзан өвчний дэгдэлттэй сумдын нөхцөл байдалтай танилцах, тэмцэх сэргийлэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр”, Улсын онцгой комиссын 2023 оны 01 дугаар сарын 05-ны 1 анхдугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцах, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Хяналт шалгалт хамрах хүрээ

Малын гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм хэрэгжүүлж байгаа сумдын Онцгой комисс, Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжийн эмч нарын хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах,

Гурав. Хугацаа

2023 оны 01 дүгээр сарын 11 -ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 13-ны хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн

Аймгийн онцгой комиссын гишүүнээр ахлуулсан Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын хамтарсан ажлын хэсэг хэрэгжүүлнэ.

Тав . Хийгдэх ажлууд:

1). Монгол улсын Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоол, 2019 оны 266 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 187 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/04 дүгээр тушаал нь Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх зааврын дагуу үр дүнтэй танилцах, хорио цээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн, малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтад авах талаар үүрэг чиглэл өгөх, зөвлөн туслах.

2). Малын гоц халдварт бог малын мялзан өвчний халдварын голомтыг хяналтад авах, тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй бодит байдалтай танилцах

3). Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт иргэдийн зорчих хөдөлгөөн бүх төрлийн тээврийн хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлын зохион байгуулалттай танилцах, явцын хяналт тавих



4). Бог малын мялзан өвчний халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж буй шат шатны төр, хувийн хэвшлийн байгууллага, албан тушаалтан, малчид иргэдийн оролцоо хамтын ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, сумдын Онцгой комисст үүрэг чиглэл, өгч ажиллах.

Тав. Хяналт шалгалтын дүнг танилцуулах

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн удирдамжаар хийгдсэн хяналт шалгалтын ажлын дүнг нэгтгэж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

\_\_\_оОо\_\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 13-ны өдрийн дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт

АЙМГИЙН АЖЛЫН ХЭСЭГ ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Чиглэл	Ажиллах сум	Орон нутагт томилолтоор ажиллах						Шатахууны зардал					Нийт зардал
			Ажиглагч хүн	Хоолны зардал /24000 төгрөг/	Байрны зардал /40000 төгрөг/	Дүн	Явах чиглэл	Явах км	Багт км	Шатахуун				
1	1 дүгээр чиглэл	Тосонцэнгэл	6	1	144,000	240,000	384,000	Мөрөн- Тосон	65	200	265	53	137,270	521,270
2		Их- Уул	6	1	144,000	240,000	384,000	Тосон- Их-Уул	47	200	247	49.4	127,946	511,946
3		Рашаант	6	1	144,000	240,000	384,000	Их- Уул- Рашаант	95	200	295	59	152,810	536,810
4								Рашаант- Мөрөн	135		135	27	69,930	69,930
	2 дугаар чиглэл	Дүн	6	3	432,000	720,000	1,152,000		342	600	942	188.4	487,956	1,639,956
1		Төмөрбулаг	6	1	144,000	240,000	384,000	Мөрөн- Төмөрбулаг	73	200	273	54.6	141,414	525,414
2								Төмөрбулаг- Мөрөн	73		73	14.6	37,814	37,814
		Дүн	6	1	144,000	240,000	384,000		146	200	346	69.2	179,228	563,228
		Нийт		4	576,000	960,000	1,536,000		488	800	1288	257.6	667,184	2,165,370

оОо